



МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

20.19 оны 09 сарын 04 өдөр

№ 01.....

Улаанбаатар хот

БҮХ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулга өгөх тухай

Тендерийн баримт бичгээс дараах тодруулгыг авахаар ирүүлсэн.

Тодруулга асуулт.

№	Тендерийн баримт бичгийн нэр	Заалтын дугаар	Тодруулга авах хүсэлт
1	Тендерийн маягт	-	Тендерийг ямар маягтаар бэлтгэх
2	Тендерийн үнэлгээний арга	-	Харьцуулалт, чанарын үнэлгээ, хосолмол арга г.м-ийн аль нь болох
3	Тендерийн үнийн задаргаа	-	Тендерийн үнийн задаргааны тусгайлсан маягт байх эсэх
4	Тендерийн урилга	3	"5,000,000-ийн ... баталгаа ..." гэснийг тодруулах
5	ТШӨХ	4.4-3	"Монгол улсад болон Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий үнэлгээчингэй байх" гэдгийг юу гэж ойлгох, "... Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий үнэлгээчингэй байх" гэдгийг гэрчлэх ямар бичиг баримт байх вэ?
6	ТШӨХ	4.4а	"Тендерт оролцогчийн сүүлийн 10 жилийн аль нэг жилийн турш гүйцэтгэсэн үйлчилгээний тоо хэмжээ нь хамгийн багадаа 200 хөрөнгө, санхүүжилтийн хэмжээ 15 сая төгрөгтэй тэнцэхүйц байна" гэснийг ямар хэлбэрээр, ямар бичиг баримтаар хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд тендерт оролцогчийн зүгээс бэлтгэх вэ?
7	ТШӨХ	4.4г	"Монгол улсад болон Олон улсад ажиллаж байсан туршлага бүхий менежертэй байх" гэдгийг юу гэж ойлгох, "... Олон улсад ажиллаж байсан туршлага бүхий менежертэй байх" гэдгийг гэрчлэх ямар бичиг баримт байх вэ?
8	ТШӨХ	33.1	Гүйцэтгэлийн баталгааны дүн

1. Тендерийг Зөвлөхийн бус үйлчилгээний тендерийн жишиг баримт бичгийн маягтаар бэлтгэнэ.
2. Шаардлагад нийцсэн тендерт оролцогчдоос тухайн багцад ирүүлсэн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг (хамгийн сайн) үнэлэгдсэн тендер гэж үзнэ.
3. Тендерийн үнийн задаргаа ирүүлэх шаардлагатай бөгөөд багц тус бүрд үнийн саналаа тусад нь ирүүлэх ёстой. Тендерийн үнийн задаргааны тусгайлсан маягт байхгүй.
4. Нийт батлагдсан төсвийн үнийн дүнгийн 2%-тай тэнцэх тендерийн баталгааны нийлбэр дүн 5 сая төгрөг гэж орсон, энэ нь 5 сая төгрөгийн баталгаа ирүүлнэ гэсэн ойлголт биш. Тендерт оролцогч өөрийн оролцох багцын санал болгож буй үнийн дүнгийн 2%-тай тэнцэх төгрөг, эсхүл түүнтэй дүйцэхүйц дүн бүхий чөлөөтэй хөрвөх валют бүхий тендерийн баталгааг багц тус бүрээр ирүүлнэ.
5. Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээчин гэж Сангийн сайдын 2010 оны 112 тоот тушаалаар батлагдсан Хөрөнгийн үнэлгээчнийг сонгон шалгаруулж эрх олгох, тусгай зөвшөөрлийг сунгах журмын дагуу Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтийн холбогдох сургалтад сууж үнэлгээчний эрх авсан үнэлгээчинг хэлнэ.

Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээчин гэж “Royal Institution of Chartered Surveyors” байгууллагын үнэлгээчний сургалтад сууж үнэлгээчний эрх авсан үнэлгээчинг хэлнэ.


6. Тухайн үйлчилгээг гүйцэтгэх гэрээ, болон ажил, үйлчилгээг хүлээлцсэн баримт бичгийн хуулбараар ирүүлэх.

7. Байгууллагыг төлөөлж МУХБ-тай гэрээ хийх эрх бүхий албан тушаалтан буюу үнэлгээний баг удирдах эрх бүхий этгээдийг ойлгоно.

8. Гүйцэтгэлийн баталгааны үнийн дүн гэрээний үнийн дүнгийн 5% байна.

Үнэлгээний хорооны дарга:

Я.Сод-Эрдэнэ



Дэд захирал бөгөөд ХШТГ-ын захирал

Хянасан:

Д.Цогтбаатар




ЗЭУХ-ийн захирал

Боловсруулсан:

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга:

Ч.Тавансахъяа



ЭУГ-ын БЭУХ-ийн мэргэжилтэн